



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 09 сарын 19 өдөр

Дугаар А/590

Булган сум

Монгол Улсын Ерөнхий сайд асан А.Амарын түүхэн замнал, үйл хэргийг сурталчлан таниулах арга хэмжээнд хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалт, аймгийн Засаг даргын 2025 оны “Засаг даргын нөөц хөрөнгөөс тусламж, дэмжлэг олгоход баримтлах журам” батлах тухай А/377 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Монгол Улсын төр, нийгмийн нэрт зүтгэлтэн, Монгол Улсын Ерөнхий сайд асан Агданбуугийн Амарын мэндэлсний 140 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх бэлтгэл ажлын хүрээнд 2025 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр түүний түүхэн замнал, үйл хэргийг сурталчлан таниулах арга хэмжээг зохион байгуулсугай.

2. Арга хэмжээг зохион байгуулахад шаардагдах зардал 4,906,000 (дөрвөн сая есөн зуун зургаан мянга) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцийн хөрөнгөөс санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА Д.ПҮРЭВ-ОЧИР



Аймгийн Засаг даргын 2025 оны  
09 дүгээр сарын 19-ны/ний өдрийн  
А.590 дугаар захирамжийн хавсралт

Монгол Улсын Ерөнхий сайд асан А.Амарын түүхэн замнал,  
үйл хэргийг сурталчлан таниулах арга хэмжээний зардал

Д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	2	3	4	5	6
1	Хулдаасан хэвлэл /Музей/	М	Урт-3,10 Өндөр-2	-	110,000
2	Хулдаасан хэвлэл /Хөгжимт жүжгийн театр/	1ш	3*4=12 м2	180,00	216,000
3	Стекр хэвлэл	40*60	20 ширхэг	20,000	400,000
4	Хэвлэлийн эх бэлтгэл	ш	4	50,000	200,000
5	Илтгэгчийн зардал	-	-	1,500,000	1,500,000
6	ХЖТ /лед зөөвөрлөх зардал портер/	ш	2	30,000	60,000
7	Айраг	45л	-	8,000	360,000
8	Ааруул	4кг	-	30,000	120,000
9	Ус, ундаа	-	-	-	100,000
10	Гарын бэлэг	ш	10	64,000	640,000
11	Өдрийн хоол	ш	10	60,000	600,000
12	Оройн хоол	ш	10	60,000	600,000
<b>Нийт төсөв</b>					<b>4,906,000</b>